**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН**
**АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН**

# З А Р Л И Г

***1962 он 4 дугаар сарын 17 өдөр, дугаар 82***
***Улаанбаатар хот***

Хөвсгөл, Төв, Увс, Баян-өлгий аймгуудын
Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх
Захиргаадын хүсэлтийн тухай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс Т О Г Т О О Х Н Ь:

1.Хөвсгөл аймгийн Зүрх сумыг татан буулгаж, Галт сумтай, Цагаан-уул сумыг татан буулгаж Шарга сумтай нийлүүлэн Шарга сумыг Цагаан-уул гэж нэрлэх;

2.Төв аймгийн Баянчандмань сумыг татан буулгаж Борнуур сумтай;

3.Увс аймгийн Улиастай сумыг татан буулгаж Өмнө-говь сумтай;

4.Баян-өлгий аймгийн Ховд сумыг татан буулгаж 89 өрхийг Цагааннуур суманд, бусды нь Ногооннуур суманд тус тус нийлүүлсүгэй.

5.Улаанбаатар хотын Гачууртайн сангийн аж ахуй, Төв аймгийн Их Хайрханы уурхайд тус бүр хороо захиргаа байгуулсугай.

БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА (Ж. САМБУУ)

БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ОРЛОГЧ ДАРГА (Д. БАЛЖИННЯМ)

БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА (Н. ЛУВСАНЧҮЛТЭМ)

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮН (Ж. ЁЯМБАДОРЖ)
(Ц. ДАМДИНСҮРЭН)
(Х. МУСАХААН)
(С. УДВАЛ)
(Д.ЯДАМСҮРЭН)
/Д.Төмөр-очир/